БАГАХАНГАЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ
/хагас жил/

| № | д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв мян.т | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ | | | | | | | | |
| **Зорилго 1**: Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж, тусламж, үйлчилгээний хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлнэ. | | | | | | | | |
| 1. | 1.1 | “Хүн төв”-тэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бий болгох загварчлалын хэрэгжилтийг ханган ажиллана. | | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | - | 20% | НЭМГ, МУИС-ын хамтран зохион байгуулсан сургалтанд 1 ажилтанг хамруулж амжилттай төгссөн.<br>Байгууллагын хэмжээнд “ Хүн төв”-тэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг бий болгох төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулахаар санал авч, нэгтгэлийг хийн ажиллаж байна. | 100 |
| **Зорилго 2:** Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийг эрчимжүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанаржуулан, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, нэр төрлийг нэмэгдүүлж, хүртээмжийг сайжруулна. /МУХТЖТ-2.2.2, 2.2.8, МУХТЖҮЧ-2.2.1, НХТЖҮЧ-2.5, 2.6, 2.7, 2.9.1, 2.9.2, 2.11.1, НЗДҮАХ- 2.1, НХЖТ-2.1/ | | | | | | | | |
| 2. | 2.1 | Хүүхэд өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна. | - | Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн сургалтын тоо | 3 | 5 | Өсвөр үеийн хүүхдүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг ерөнхий боловсролын 94, 91 дүгээр сургуулиудтай хамтран<br>- Нөхөн үржихүйн эрүүл мэнд сэдвээр -2 удаа<br>- Электрон тамхины хор уршиг сэдвээр 1 удаа<br>- Дархлаажуулалтын ач холбогдол сэдвээр 2 удаа тус тус зохион байгуулсан. | 100 |
| | | | | Хамрагдсан иргэдийн тоо | 158 | 160 | Өсвөр үеийн хүүхдүүдэд зориулсан сургалтанд нийт давхардсан тоогоор 97 хүүхдийг хамруулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3. | 2.2 | Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулна. | | Зохион байгуулсан сургалтын тоо | 27 | 32 | Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах төлөвлөгөөг 23 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг ханган ажилласнаар 2026 он 06 дугаар сарын 01-ний байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай хэрэгжиж байна.<br>Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран амьдралын зөв дадлыг олгох, эрүүл мэндийн зөв мэдээллийг авах 12 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 224 иргэнийг хамруулсан.<br>-Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох мэдээлэл хүргэх зорилгоор байгууллагын вэб сайт болон цахим хуудсанд 12 төрлийн 74 мэдээлэл, зөвлөмжийг байршуулж түгээсэн ба хандалт 5678 байна.<br>-Байгууллагуудын ажилчдын урьдчилан сэргийлэх үзлэгт 4 байгууллагын 146 албан хаагчид үзлэгт хамрагдсан. | 95 |
| | | | | Хамрагдсан иргэдийн тоо | 328 | 350 | | |
| 4. | 2.3 | Сүрьеэ өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна. | | Шинэ өвчлөлийн тохиолдлын эзлэх хувь | 3,2 | 3,0 | -2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар амбулаторын үзлэгт тулгуурлан урьдчилан сэргийлэх үзлэгт давхардсан тоогоор 1383 иргэн хамрагдсан.<br>-2026 оны эхний хагас жилд шинэ тохиолдол бүртгэгдээгүй.<br>-Жил бүр сүрьеэтэй тэмцэх өдрийг тохиолдуулан Сүрьеэгийн Нийгэмлэгтэй хамтран дүүргийн иргэдийг “Уушигны эмгэг болон | 100 |
| | | | | Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилтын хувь | 82 | 85 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | сүрьеэ өвчин”-ийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж ажиллаж байгаа болон 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдөр нийт 90 иргэдийг үзлэг, шинжилгээнд хамруулсан. Үзлэгийн үр дүнд үзлэгт хамрагдсан нийт иргэдээс сэжигтэй 2 тохиолдлын сорьцыг ХӨСҮТ-д баталгаажуулах шинжилгээнд сорьцыг тээвэрлэн хүргэж өгсөн. Шинжилгээний хариу бүгд сөрөг гарсан.<br>2026 оны эхний хагас жилд шинээр хяналтанд авсан тохиолдол бүртгэгдээгүй.<br>2025 онд хяналтанд байсан 1 иргэн эмчилгээ, хяналтыг тогтмол хийж ажиллаж байна.<br>Хяналтын хугацаанд 2026 онд Эмчилгээний явцад хордлого тайлах эмчилгээ 2 удаа, явцын шинжилгээг 2 удаа тус тус хамруулсан байна. | |
| 5. | 2.4 | БЗДХ-ийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулна. | - | Шинэ өвчлөлийн тохиолдлын эзлэх хувь | - | - | 2026 оны эхний хагас жилийн байдлаар БЗДХ/ДОХ-ыг илрүүлэх зорилгоор түргэвчилсэн оношлуураар<br>- ДОХ 160<br>- Тэмбүү-176 нийт 336 иргэнийг шинжилгээнд хамруулсан.<br>Эхний хагас жилийн төлөвлөсөн ажлын хэрэгжилт 90%-тай байна.<br>БЗДХ/ДОХ тэмбүүгийн сэжигтэй 2 тохиолдлыг илэрч баталгаажих шинжилгээнд хамруулсан. Баталгаажуулах шинжилгээнд 1 жирэмсэн эх тэмбүү эерэг гарч гэр бүлийн хамт үе шаттай эмчилгээг хийж, эмэгтэйчүүдийн эмч зөвлөгөө | 90 |
| | | | - | Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилтын хувь | - | 70 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өгч хяналт тавьж ажиллаж байна. | |
| 6. | 2.5 | Товлолт дархлаажуулалт хамрагдалтыг нэмэгдүүлэх, хяналтыг сайжруулж дархлаажуулалтын урвал хүндрэлээс сэргийлэх ажлыг зохион байгуулна | - | Товлолт дархлаажуулалтын хамрагдалтын хувь | 95 | 95 | Товлолын дархлаажуулалт хамралтыг нэмэгдүүлэх чиглэлээр аж ахуй нэгж байгууллагууд 2 удаа сургалтанд 246 хүнийг хамруулсан.<br>Хүний папилома вирусын товлол дархлаажуулалт 11 настай хүүхдийн хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор 91, 94-р сургуулийн 5-р ангийн эцэг эхчүүдэд эмэгтэйчүүдийн их эмч З.Түвшинсайхан их эмч Э.Төвшинжаргал нар сургалт зохион байгуулан 67 эцэг эхчүүд хамрагдсан.<br>2026 оны 5 сарын байдлаар товлолт дархлаажуулалтанд 276 хүүхэд хамрагдахаас 243 хамрагдаж 88 хувьтай байна. Хүний папилома вирусын сургалт сурталчилгааг нэмэгдүүлснээр 2026 оны 11 настай дархлаажуулалт 88 хувь хийгдснээр 2025 онтой харьцуулахад 22.4хувиар өссөн байна. | 88 |
| 7. | 2.6 | Тархвар судлалын заалтаар хийгддэг дархлаажуулалтын ажлыг чанартай зохион байгуулж хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | Дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгө, Байгууллагын төсөв | Хамрагдалтын хувь | 94,5 | 95 | Тархвар судлалаар 2026 онд хачиг энцефалитын дархлаажуулалт 38 хүн татан авч дархлаажуулалт 100 хувь хийгдсэн.<br>Галзуугийн дархлаажуулалтанд 5 хүн хамрагдахаас 4 хүн бүрэн тунд хамрагдаж дархлаажуулалт 80 хувьтай хийгдсэн байна | 80 |
| 8 | 2.7 | "Эрүүл шүд" арга хэмжээг хэрэгжүүлж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын болон ерөнхий боловсролын | - | Хамтран ажилласан эрүүл мэндийн байгууллагын тоо | 2 | 2 | Засгийн газрын 2023 оны 322 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл шүд” арга хэмжээний хэрэгжилтийн хүрээнд: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | сургуулийн суралцагсдыг амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж эрүүлжүүлэх арга хэмжээг зохион байгуулна. | | Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон хүүхдийн тоо | 581 | 600 | -Дүүргийн Сургуулийн өмнөх боловсролын байгууллагуудтай хамтран амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт 267 хүүхдийг хамруулсан.<br>Үүнд:<br>- 44-р цэцэрлэгийн 5 бүлгийн 138 хүүхэд<br>- 207-р цэцэрлэгийн 90 хүүхэд<br>- УБТЗ-н харьяа 183-р цэцэрлэгээс 40 хүүхдийг тус тус хамруулсан.<br>2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар хүүхдийн эмч урьдчилан сэргийлэх үзлэгийг хийсний үр дүнд 0-18 насны 476 хүүхдээс 167 хүүхэд амны хөндийн эмчилгээ хийлгэх шаардлагатай байна.<br>Эрүүлжүүлэлтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Тус төлөвлөгөөний хүрээнд<br>- Цэцэрлэгийн байгууллагын багш, ажилчид болон хүүхдүүдийн ар гэрийнхэнд 1 удаа зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулж 167 иргэнийг хамруулж зөвлөгөө өгч ажилласан.<br>2026 оны 05 дугаар сард НШЭНТ-ийн 5 эмчийн бүрэлдэхүүнтэй баг ирж ажилласнаар 64 хүүхдийг эрүүлжүүлж эмчилгээ хийсэн ба эрүүлжүүлэлт 38%-тай байна. | |
| | | | | Эмчилгээнд хамрагдаж эрүүлжсэн үзлэгийн хувь | 75 | 80 | | |
| 9. | 2.8 | Зорилтот бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг, | | Сургалтын тоо | 6 | 10 | Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар 10 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө олгосон. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | мэдээлэл олгох сургалт нөлөөллийн ажлыг эрчимжүүлэх, жирэмслэхээс сэргийлэх арга хэмжээг нэмэгдүүлнэ. | | | | | Гурван гэр бүлд зөвлөгөө өгч жирэмслэхээр төлөвлөсөн байсан тул урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, одоогоор 2 гэр бүл жирэмсний хяналтанд орсон байна<br>ЕБС 94 дүгээр сургуулийн 2026.03.20 нд 8–12 дугаар ангийн нийт 31 охинд дараах сэдвээр сургалт зохион байгуулсан:<br>o Биений юмны мөчлөг, хэвийн ба хэвийн бус өөрчлөлт<br>o Хувийн ариун цэвэр<br>o Бэлгийн амьдрал ба нөхөн үржихүйн эрүүл мэнд<br>o Эрүүл зан үйл төлөвшүүлэх<br>ЕБС 94 дүгээр сургуулийн 2026.03.30 нд 5-7 дугаар ангийн нийт 23 охинд дараах сэдвээр сургалт зохион байгуулсан:<br>• Биений юмны гэж юу вэ?<br>• Биений юмны ирэх үед хувийн бэлтгэлээ хэрхэн хангах вэ?<br>• Охидын хувийн ариун цэвэр, ариун цэврийн хэрэглэл зөв хэрэглэх алхам<br>• Эрүүл зан үйл төлөвшүүлэх зэрэг сургалт зохион байгуулсан.<br>91 дүгээр сургуулийн 5 дугаар ангийн сурагчдын 12 эцэг эхчүүдэд дараах сэдвээр сургалт зохион байгуулсан:<br>• Өсвөр насны охидын бие физиологийн өөрчлөлт<br>• Хувийн ариун цэвэр<br>• Умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх<br>• HPV вакцин<br>• Эцэг эхийн оролцооны ач холбогдол | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | УБТЗ байгууллагын 34 ажилтнуудад дараах сэдвээр сургалт зохион байгуулсан:<br>• Умайн хүзүүний хавдраас урьдчилан сэргийлэх<br>• Бэлгийн ариун цэвэр<br>• Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн ач холбогдол<br>HPV халдвар ба дархлаажуулалтын талаар мэдээлэл түгээсэн. | |
| | | | | Сургалтад хамрагдсан жирэмсний тоо | 32 | 50 | Жирэмсэн эхчүүдэд зориулсан 8 удаагийн уулзалтыг зохион байгуулж сургалтанд -38 эх бүрэн 100% хамрагдсан.<br>1-р уулзалт – Жирэмсний физиологи, хяналт<br>2-р уулзалт – Хооллолт, амьдралын хэв маяг<br>3-р уулзалт – Ургийн хөгжил, эхо өөрчлөтийг<br>4-р уулзалт – Аюултай шинж тэмдэг<br>5-р уулзалт – Төрөхөд бэлтгэх<br>6-р уулзалт – Өвдөлт намдаах, амьсгал<br>7-р уулзалт – Нярай асаргаа<br>8-р уулзалт – Хөхөөр хооллолт, гэр бүл төлөвлөлт зэрэг хичээлүүдийг бэлтгэж 12 удаа бүлгийн сургалтыг хийсэн. | 100 |
| | | | | Жирэмслэхээс сэргийлэх арга хамрагдсан зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн тоо | 733 | 750 | 2026 онд зорилтот бүлгийн НҮНЭ-213 эмэгтэйчүүдийн судалгааг шинэчлэн гаргасан. Үүнд:<br>1. 19-өөс доош насны бэлгийн хавьталд орсон охид-8<br>2. Халамж, эмзэг бүлгийн-17<br>3. Нэн ядуу-4<br>4. Хорт зуршил тогтмол | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэрэглэдэг- 4<br>5. Хүчирхийлэлд байдаг-0<br>6. 5-аас олон төрсөн -18<br>7. Өмнөх жирэмслэлт, төрөлтөнд хүндрэлтэй байсан- 8<br>8. 2-оос дээш кесар мэс заслаар төрсөн-14<br>9. Ураг, нярай нь эндэж байсан-2<br>10. Удамшлын болон төрөлхийн хөгжлийн гажигтай хүүхэд төрүүлж байсан-2<br>11. Эрхтэн тогтолцооны хүнд эмгэгтэй-11<br>12. 0-2 насны хөхүүл хүүхэдтэй-98<br>Зорилтод бүлгийн эхчүүдэд зохиулсан гарын авлага 32 ш тараасан. | |
| | | | | Хамрагдалтын хувь | 70 | 75 | Жирэмслэхээс сэргийлэх арга хамрагдсан зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн тоо -129 хамруулсан ба хамрагдалт 60,2%-тай байна.<br>• Ерөндөг-37<br>• Суулгац-18<br>• Тариа- 6<br>• Эм-26<br>• Бэлгэвч-42<br>Өмнөх оноос 14,9% өссөн. | 100 |
| 10. | 2.9 | Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр аян зохион байгуулж иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх ажлыг зохион байгуулна | | Аянд хамрагдсан иргэний тоо | 120 | 150 | Осол гэмтлийн сарын аяны төлөвлөгөөг 9 заалттайгаар боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж хэрэгжилт 92%-тай байна:<br>Аяны хүрээнд 4 байгууллагад осол гэмтлээс сэргийлэх, түүнээс үүсэх эрсдлээс сургалтыг зохион байгуулж 79 иргэнийг хамруулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 11. | 2.10 | Бага насны хүүхдийн суурь өвчлөл хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэн, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн ажиллана | | Илрүүлэгт хамрагдах хүүхдийн тоо | 345 | Тухай бүрт | 2021/06/17-ны ЭМС-н А/379 тоот тушаалын дагуу 0-5 насны хоол тэжээлийн цочмог дутлыг илрүүлэх үзлэгт хагас жилийн байдлаар 466 хүүхдийг 3А маягтаар үнэлж 4 хүүхэд хоол тэжээлийн цочмог дутал илрүүлсэн ба 2 хүүхэд нь улаан хоолоын төрөлхийн битүүрлийн улмаас хагалгаанд орсон хүүхэд байна. | 100 |
| | | | | Илрүүлсэн хүүхдийн тоо | 6 | Тухай бүрт | 4 хүүхдийн 3 хүүхдийг амьсгалын эрхтний эмгэгийн улмаас хүүхдийн тасагт хэвтүүлэн эмчлэв | 100 |
| | | | | Эрүүлжүүлэлтийн хувь | 76 | 80 | Эмчилгээний бэлэн хоол байхгүй тул ар гэрт хооллотын зөвлөгөө, халдвараас сэргийлэх зөвлөгөө, хүндрэлийн зөвлөгөөг өгч ажиллаж байна. | 90 |
| 12. | 2.11 | Зорилтод бүлгийн (Эрүүл мэндийн 4,5-р бүлэг) болон туранхай, тураалтай, өсөлтийн хоцрогдолтой, сульдаатай хүүхдүүдэд сар бүр хий гэрийн эргэлтийг чанаржуулах, эрүүл мэндийг хамгаалах ажлыг зохион байгуулна. | | Хорооны нийгмийн ажилтантай хамтран сар бүр хийсэн гэрийн эргэлтийн хувь | - | 100 | Хөгжлийн бэрхшээлтэй 28 хүүхэд байгаа бөгөөд 0-5 насны 6 хүүхэд байсан ба 1 хүүхдийн биеийн байдал сайжран тогтворжсон тул ЭХЭМҮТ-н оношийг үндэслэн хяналтаас гаргасан. 4-5р бүлгийн 7 хүүхдийн гэрийн эргэлтийг хуваарийн дагуу хийж ажиллаж байна. | 100 |
| 13. | 2.12 | Нярайн гэрийн эргэлтийг чанаржуулж, үзлэг, хяналтыг сайжруулж ажиллана. | | Гэрийн эргэлт хийх нярайн тоо | 64 | Тухай бүр | Шинээр 34 нярайн гэрийн эргэлтийг давхардсан тоогоор 180 удаагийн гэрийн эргэлтийг хийж лавлагаа шатлалд хүнд шарлалттай 4 нярайг лавлагаа шатны төрөх эмнэлэгт шилжүүлж эмчилгээг шийдлвэрлүүлэн хэвтүүлсэн ба эмнэлгээс гарсан үеийн хяналтыг тогтмол хийж ажиллаж байна.: | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Нярайн гэрийн эргэлтийн хувь | 89 | 92 | Нярайн гэрийн эргэлтийг 72 цагтаа 100% эхний 1 сард 4-6 удаа 2дахь сард 2-3 удаа үзэж тухай бүрийн зөвлөгөө өгч ажилласан. | 100 |
| 14. | 2.13 | Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, хүрээлэн буй орчинд ээлтэй эрүүл мэндийн байгууллага болох төлөвлөгөөг батлуулж хэрэгжилтийг ханган ажиллана. | | Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 25 | Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй, хүрээлэн буй орчинд сэдэвт сургалтанд Нийгмийн эрүүл мэндийн эмч Г.Болдыг 1 удаа хамруулсан.<br>Байгууллагын хэмжээнд зохион байгуулах ажил, арга хэмжээний хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна | 80 |
| 15. | 2.14 | Халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах чиглэлээр нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулж, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтыг нэмэгдүүлнэ. | | Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь | 67,3 | 70 | Артерийн гипертензи эрт илрүүлэгийн үзлэгт 2822 хүн хамрагдахаас 435 хамрагдаж 15.4 хувь, | 80 |
| | | | | Чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь | 76,9 | 78 | Чихрийн шижин хэв шинж-2 үзлэгт 1728 хүн хамрагдахаас 976 хамрагдаж 25.2 хувь, | 80 |
| | | | | Хөхний хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн хамрагдалтын хувь | 55,2 | 60 | Хөхний хавдрын эрт илрүүлгийн үзлэгт хамрагдвал зохих 1081 эмэгтэйчүүдээс 2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар 389 эмэгтэйчүүдийг хамруулсан.<br>Лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад онош тодруулахаар 2 эмэгтэйг явуулсан.<br>Хамрагдалт 36%-тай байна. | 100 |
| | | | | Умайн хүзүүний хавдрын эрт илрүүлгийн үзлэгийн | 41 | 220 | Умайн хүзүүний хавдрыг эрт илрүүлгийн үзлэгт 316 хамрагдахаас 154 хамрагдаж 38.7 хувьтай тус тус байна. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамрагдалтын тоо | | | Умайн хүзүүний хавдрыг илрүүлэх шинжилгээнээс 12 иргэнийг лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагад онош тодруулахаас илгээснээс 2 хавдар батлагдаж эмчилгээ шийдвэрлүүлж, 1 иргэн үгүйсгэгдсэн ба одоо 9 иргэн үзлэг, шинжилгээнд хамрагдаж байна. | |
| | | | | хамрагдалтын хувь | 10,4 | 70 | 2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар нийт-21218 үзлэг хийгдсэнээс урьдчилан сэргийлэх үзлэг-9182 хамрагдаж 43.3 хувьтай | 100 |
| **Зорилт 3.Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** - Хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлж, авлигаас урьдчилан сэргийлэх, хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлох, төлөвлөх, сургах, урамшуулах арга хэмжээг хэрэгжүүлнэ. /АХ-1.3.10, 2.2.21, МУХЖТ-1.3.1, 2.2.1/ | | | | | | | | |
| 16. | 3.1 | Байгууллагын стратеги төлөвлөгөөг боловсруулан батлуулна. | - | Батлагдсан төлөвлөгөөний тоо | - | 1 | Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг 8 бүлэг 20 зорилт 57 арга хэмжээтэй боловсруулан баталж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | 100 |
| | | | | Стратегийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | - | 20% | Байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилт 14%-тай банйа. | 100 |
| 17. | 3.2 | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг өмнөх оныхоос богиносох, иргэдэд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг иргэнд эргэн мэдээлэх ажлыг чанаржуулах, байгууллагын өргөдөл, гомдлын тохиолдлыг өмнөх оныхоос бууруулах чиглэл ажлуудыг зохион байгуулна. | - | Шийдвэрлэлтийн дундаж хоног | 8,6 | 8 | Байгууллагын удирдлага нийт 2026 оны 06 дугаар сарын 01-ны байдлаар нийт 11 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэж ажилласан.<br>ҮҮНД:<br>-2026 оны үйл ажиллагаанд хамааралгүй 2024 оны тусламж үйлчилгээтэй холбоотой 1 гомдол бүртгэгдсэн ба тухайн гомдол шүүх хяналтын байгууллагаар шалгагдаж хянагдсан ба эхний шийдвэрээр тухайн гомдлын үндэслэл байгууллагад хамаарахгүй гэж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шийдвэр гарсан.<br>-Ажилчдын харьцаа хандлагыг 1 гомдол<br>-Талархал -4<br>- хүсэлт 5 хүлээн авч шийдвэрлэж ажилласан.<br>Шийдвэрлэлтийн хувь 91%, дундаж хоног 2 хоног байна.<br>2026 оны 06 дугаар сарын байдлаар<br>- Саналын хуудсаар 159<br>- Цахим санал хүсэлт -46<br>- Ганцаарчилж уулзалт хийж хүлээн авсан 22 нийт 227 санал хүсэлтийг хүлээн авсан.<br>Санал хүсэлтийн үр дүн эерэг сэтгэл ханамж 88.8%-тай 2025 оны мөн үетэй харьцуулахад эерэг сэтгэл ханамж 0,3%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй гарсан.<br>Иргэдэд өргөдөл, санал хүсэлтийн шийдвэрлэлтийн талаар хариу мэдээлж ажилласан. | |
| | | | | Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь | 100 | 100 | 2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хувь 91%-тай байна. | 100 |
| | | | | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн зөрчлийн хувь | 10 | 5 | 2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар зөрчил бүртгэгдээгүй. | 100 |
| 18. | 3.3 | Эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдад зориулсан дотоодын сургалт, эмч, эмнэлгийн ажилчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажлын байранд дадлагажуулах ажлуудыг зохион байгуулна. | - | Сургалтын тоо | 33 | 35 | Байгууллагын дотоодын сургалтыг 7 хоног бүр зохион байгуулж ажилладаг ба дотоодын сургалтыг зохион байгуулах хуваарийг 2026 онд байгууллагын даргын 2026 оны А/08 дугаар тушаалаар эхний хагас зохион байгуулах сургалтын хөтөлбөрийг баталж хөтөлбөрийн дагуу дотоодын сургалтыг 25 удаа зохион байгуулж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажилчид давхардсан тоогоор 367 буюу хамрагдалт 89,8%-тай хамрагдсан.<br>Холбогдох байгууллагаас зохион байгуулсан танхимын 16 удаагийн сургалтанд 23 ажилтан, цахимаар зохион байгуулсан 9 нийт 38 сургалтанд холбогдох ажилчдын хамруулсан.<br>Эрүүл мэндийн салбарын гамшгийн үеийн дадлага сургуулилтанд байгууллагын гамшгийн штабын бүрэлдэхүүн, удирдлага, бичиг хэрэг нийт эрүүл мэндийн 9 ажилтан, онцгой байдлын хэлтсийн 3 албан хаагч нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр 3 өдрийн дадлага сургуулилтанд оролцсон | |
| | | | | Ажилчдын хамрагдалтын хувь | 94 | 96 | Дотоодын сургалтанд ажилчдын хамрагдалт 89,8%-тай байна. | 100 |
| 19. | 3.4 | Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах, өөрчлөх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг тасралтгүй зохион байгуулж , ёс зүйн зөрчлийг бууруулна. | - | Сургалтын тоо | 5 | 7 | Байгууллагын дотоодын сургалтаар ёс зүй чиглэлээр 2 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 24 ажилтанг хамруулсан.<br>Ажилчдын мэдлэгийг бататгах зорилгоор эмч эмнэлгийн ажилчдын ёс зүйн дүрэм, журмаар 1 удаа АХА тэмцээнийг зохион байгуулж 27 ажилтан хамрагдсан. | 100 |
| | | | | Арга хэмжээний тоо | 1 | 1 | | |
| | | | | Ажилчдын холбоотой гомдлын тоо | 1 | Тухай бүрт | | |
| 20. | 3.5 | Ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр шинэчлэн батлагдсан хууль, тогтоомж, журам байгууллагын нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг | - | Хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Байгууллагын ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх ажлын хүрээнд дээд газраас гарсан тогтоол, тушаал, шийдвэрийг цаг хугацаанд нь хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>ҮҮНД:<br>- 2026 оны 01, 05 дугаар сард | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | хангаан ажиллана. | | | | | Б/07, Б/13 дугаар тушаалаар ажилчдын үндсэн цалингийн тушаалыг шинэчлэсэн.<br>- Байгууллагын ажилчдын үндсэн цалин, нэмэгдэл хөлс, ажлын үр дүнгийн урамшууллыг тогтоол шийдвэрийн дагуу бүрэн олгож ажилласан.<br>- 2026 оны 01 дүгээр улирлын ажилчдын ажлын үр дүнгийн урамшуулалд 35,7 сая төгрөг зарцуулсан.<br>- Ажилчдын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх хамт олны эв нэгдлийг эрхэмлэх зорилгоор 5 төрөлт тэмцээнийг 1 удаа<br>Гэр бүлийн гишүүдийн дунд уламжлалт шагайн наадгай, “Гэр бүлийн үнэ цэнэ” сэдэвт сургалтыг тус бүр 1 удаа зохион байгуулж арга хэмжээ, тэмцээн уралдаанд 800,000 төгрөг зарцуулсан.<br>Дүүргийн засаг даргын тамгын газартай 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн №2026/09 дугаартай гэрээний хэрэгжилтийг ханган 7 их эмчид орон нутгийн нэмэгдлийг сар бүр ажлын гүйцэтгэлээр олгож ажиллаж байна.<br>2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар шинээр ажилд томилогдсон ажилтан-1 сувилагч, сул ажлын байрны зарыг байгууллагын цахим хуудсанд 8 удаа, XXYX-т 4 удаа хүргүүлэн ажилласан. | |
| 21. | 3.6 | ERP archive, ERP Edoc, программд хяналт тавьж, | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 99,5 | 100 | Архив, албан хэрэг хөтлөлтийн Erp.ulaanbaatar.mn | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ирсэн, явуулсан бичгийг зөрчилгүй шийдвэрлэнэ. 2025 оны зөрчлийн тоог бууруулж ажиллана. | | | | | программаар нийслэл болон дүүргийн харьяа байгууллагуудаас 285 бичиг, байгууллагын мэйл хаяг, шуудан холбоогоор 9 бичиг ирснийг хүлээн авч бүртгэж шийдвэрлэгдсэн.<br>• Хариутай бичгийн шийдвэрлэлт 90,7%<br>• Ирсэн бичгийн шийдвэрлэлтийн дундаж 96,9%<br>• Хугацаа хэтэрч хаагдсан бичиг -5 буюу 1,75%<br>• Зөрчлийн тоо-2 өмнөх оноос буурсан. | |
| 22. | 3.7 | Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, өр авлага үүсгэхгүй байх, төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнаж ажиллах. | - | Мэдээний тоо | 12 | 12 | Байгууллагын санхүүнгийн төсвийг зориулалтын дагуу эрхийг нээлгэн зарцуулж байгаа болон сарын тайлан мэдээг хугацаанд нь НЭМГ, Дүүргийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтэст төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг гаргаж, өр авлагийн тайланг хавсарган сар бүр тайлагнаж ажилласан | 100 |
| 23. | 3.8 | 2027 оны тогтмол зардлын төсвийн төсөл, 2028-2029 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд ирүүлнэ. | - | Төсвийн төсөөлөл өгсөн тоо | - | 1 | 2027 оны тогтмол зардлын төсвийн төсөл, 2028-2029 оны төсвийн төсөөллийг хуулийн хугацаанд нь хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа болон одоогоор хүлээн авах хуваарь ирээгүй | 100 |
| 24. | 3.09 | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд хүргүүлнэ. | - | Мэдээний тоо | 12 | 12 | Төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг дараа сарын 01-ний өдөр НЭМГ болон дүүргийн ЗДТГ-ын СТСхэлтэст тус бүр тайлагнаж ажиллаж байна. Хугацаа хоцроосон болон тайлагнаагүй сар байхгүй. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 25. | 3.10 | 2025 оны жилийн эцсийн санхүүгийн аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ. | - | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | | 100 | 2025 оны санхүүгийн аудитын дүгнэлтээр “ӨӨРЧЛӨЛТГҮЙ” гэж дүгнэгдсэн. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулж ажиллаж байгаа болон төлөвлөгөөний биелэлт 2026 оны 06 дугаар сарын 01-нй байдлаар 90%-тай хэрэгжиж байна. | 100 |
| 26. | 3.11 | Монгол Улсын Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-ээр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсанаас хойш ажлын 10 хоногт багтаан батлуулах, тайланг төсвийн жил дууссан даруйд системээр тайлагнана. | - | Цахим системд тайлагнасан төсөл арга хэмжээний тоо | - | Төсвийн жил дууссан нийт төсөл, арга хэмжээг системд бүрэн тайлагнасн байна. | 2026 он 06 дугаар сарын 01-ний байдлаар 21 эм хангах нийлүүлэх байгууллагаас 286 нэр төрлийн эм тариаг 31,440,393 төгрөгний худалдан авалтыг хийж нөөцийг бүрдүүлж ажилласан.<br>Үүнээс:<br>- Цахим худалдан авалтаар ба нийт худалдан авалтын 62.9 % ба 19,794,985 төгрөгний худалдан авалтыг хийсэн. | 100 |
| 27. | 3.12 | Хүүхдийн тусламж, үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтний мэдлэг ур чадварыг сайжруулах ХӨЦМ-ийн сургалтыг зохион байгуулна. | - | Сургалтын тоо | 1 | 1 | Хүүхдийн тусламж, үйлчилгээний чиглэлээр эмч, мэргэжилтний мэдлэг ур чадварыг сайжруулах ХӨЦМ-ийн сургалтанд хүүхдийн эмч 2 удаа хамрагдсан.<br>Байгууллагын дотоодын сургалтын цагт тулгуурлан 5 их эмчид ХӨЦМ-ийн сургалтыг 3 удаа зохион байгуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | - | Хамрагдсан ажилтны тоо | 4 | 8 | ХӨЦМ-ийн сургалтанд 2 их эмч хамрагдсан. | 100 |
| 28. | 3.13 | Шинээр ажилд орсон сувилагч нарыг шинэ сувилагчийн хөтөлбөрт хамруулна. | | Шинээр ажилд орсон сувилагчаас сургалтад хамрагдсан хувь | 100 | Тухай бүрт | Шинээр ажилд орсон сувилагч нарыг ажлын байранд дадлагажуулах, сургах хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган 2026 оны эхний хагас жилд 1 шинэ төгссөн сувилагчийг ажлын байранд сургах хөтөлбөрт хамруулсан. | 100 |
| | | | | Шинэ сувилагчаас үзүүлсэн тусламж, үйлчилгээтэй холбоотой таагүй ба ноцтой тохиолдлын тоо | 0 | 0 | Зөрчил, ноцтой тохиолдол бүртгэгдээгүй | 100 |
| 29. | 3.14 | Худалдан авах үйл ажиллагааг Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль болон холбогдох журамд нийцүүлэн ил тод шуурхай, зохион байгуулж хугацаанд нь чанартай гүйцэтгэж ажиллана. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | Төрийн хэмнэлтийн хууль, санхүүгийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа тушаал шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>2026 онд тухай бүр Е-баримтаар үүссэн нэхэмжлэлийг үндэслэн гүйлгээг цахимд бүрэн шилжүүлсэн.<br>Гүйлгээг finance.gov.mn программыг бүрэн ашиглаж байна. | 95 |
| 30. | 3.15 | Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн “Дотоодын үйлдвэрээс бараа, материал худалдан авах” 90 дүгээр тогтоолын дагуу чанар стандартын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчээс худалдан авна. | - | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 100 | 100 | “Дотоодын үйлдвэрээс бараа, материал худалдан авах” 90 дүгээр тогтоолын дагуу хэрэгжилтийг ханган<br>• Хэвлэмэл бүтээгдэхүүнээс 4 нэр төрлийн албан бланк 275,150 төгрөгөөр худалдан авалт хийсэн.<br>• 24 нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг 18 сая төгрөгөөр худалдан авалт | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хийсэн. | |
| 31. | 3.16 | Засгийн газраас хэрэгжүүлж буй 5Ш ажиллагааны хүрээнд мэдээллийн ил тод байдлын Shilen.gov.mn сайтад эрүүл мэндийн байгууллага нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж ажиллана. | | Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу улирал бүр мэдээлэл оролцуулах | 75,9 | 80 | Засгийн газраас хэрэгжүүлж буй 5Ш ажиллагааны хүрээнд мэдээллийн ил тод байдлын Shilen.gov.mn сайтад эрүүл мэндийн байгууллага нээлттэй мэдээллийг цахим хэлбэрээр байршуулж тайлагнах ажлыг хугацаанд нь 2026 оны 04 дүгээр сарын 30-ны дотор илгээсэн ба 1 дүгээр улирлын дүгнэлттэй холбоотой хяналт, шалгалтыг хийсэн мэргэжилтэнтэй холбогдож цаашид анхаарах зөвлөмжийг авч 2 дугаар улиралд үнэлгээний дүгнэлтийг нэмэгдүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. | 70 |
| 32. | 3.17 | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заалтад Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж заасан тул эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр хангаан байнгын хяналт тавьж ажиллана. | | Тоног төхөөрөмжийн тоо | - | 1 | Байгууллагын мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр хангах чиглэлээр шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг гарган НЭМГ болон дүүргийн ЗДТГ-т албан бичгээр хүргүүлэн ажилласан.<br>2027 онд хийгдэх хөрөнгө оруулалтын ажилд тусгуулахаар төсвийн тооцооллыг хийн НЭМГ-т хүргүүлсэн.<br>Байгууллагын нөөц боломжоондоо тулгуурлан ашиглаж байгаа компьютер тоног төхөөрөмжийг 2026 онд 2 удаа засвар үйлчилгээг хийлгэж шаардлагатай 765,000 төгрөгийг шийдвэрлэн ажилласан. | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Хийгдсэн ажлын тоо | - | 1 | Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган холбогдох мэргэжилтэнг 2 удаагийн сургалтанд хамруулсан.<br>Мэдээллийн аюулгүй байдлын аудит, үнэлгээг хийлгэхээр холбогдох 2 байгууллагаас үнийн саналыг авсан ба санхүүгийн асуудлыг шийдвэрлэхээр судалж байна. | 80 |
| **Зорилт 4. Дүрмээр хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт** - Эрүүл мэндийн байгууллагуудын материаллаг бааз, барилга, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, автомашин ашиглалт, засвар үйлчилгээ нөхөн хангалтыг нэгтгэн зохион байгуулна. /НХТЖТ-2.11.1/ | | | | | | | | |
| 33. | 4.1 | Лабораторийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор нэр төрлийг нэмэгдүүлэх, тоног төхөөрөмжийг судалж, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлнэ. | - | Нэмэгдсэн нэр төрлийн тоо | 1 | 1 | Лабораторийг стандартын дагуу тохижуулах ажлыг 2026 оны 01 дүгээр улиралд багтаан хийж засварын ажилд нийт 6,962,000 төгрөг зарцуулсан.<br>Лабораторийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай байгаа шээсний аппаратын албан хүсэлтийг НЭМГ-1 удаа, дүүргийн Засаг дарга -1 удаа, ВИМ, МЕД ХХК-1 удаа тус тус хандаж хүргүүлэн дэмжлэг хүссэн.<br>Лабораторийн тусламж үйлчилгээг хийхэд шаардлагатай 42 нэр төрлийг урвалж, бодис уусмалыг татахад 18,2 сая төгрөгийг шийдвэрлэж зарцуулсан. Урвалжийн тасалдал хүндрэл үүсээгүй. | 100 |
| | | | | Шинжилгээнд хамрагдсан иргэдийн тоо | 138 | 200 | 2026 онд шинээр нийлүүлэгдсэн тоног төхөөрөмж байхгүй.<br>2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар<br>- Цусны шинжилгээ -1211<br>- Шээсний шинжилгээ -1176<br>- Биохимийн шинжилгээ -635<br>- В вирус илрүүлэх -155<br>- С вирус илрүүлэх -155 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | - ДОХ илрүүлэх -160<br>- Тэмбүү илрүүлэх -176<br>- Үе мөчний үрэвсэл илрүүлэх-39<br>- Хлекобактери илрүүлэх -45<br>- Цагаан хорхойн өндөг илрүүлэх -19<br>- Цус бүлэг тодорхойлох -47 буюу нийт 3818 шинжилгээг хийсэн. | |
| 34. | 4.2 | Яаралтай, түргэн тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг сайжруулах чиглэлээр тодорхой ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, дуудлагын хүлээгдэл, чирэгдлийг бууруулна. | - | Зохион байгуулсан ажлын тоо | 4 | 5 | Яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор шаардлагатай 5 төрлийн багаж хэрэгслийг худалдан авсан ба тус ажилд 8,000,000 төгрөгийг шийдвэрлэж ажилласан<br>Яаралтай, түргэн тусламжийн ЭМС-ийн А/814, А/293 А/220 тушаалуудын хэрэгжилтэнд хяналт тавьж, эрэмбэлэлтийн ангилалыг сайжруулж хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор байгууллагын дотоодын сургалтаар 4 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 76 ажилтанг хамруулсан. | 100 |
| | | | | Дуудлагын хүлээгдлийн хугацаа | 10 | Тодорхой хугацаагаар бууруулна | Яаралтай тусламжийн дуудлагын хүлээгдлийг бууруулах ажлын гүйцэтгэлийн үр дүнд дүгнэлт хийх зорилгоор дуудлага хүлээн авсан цаг хугацаанаас дуудлаганд гарах үеийн хүлээгдлийн бүртгэлийг өдөр бүр хөтөлж дүгнэлт хийж ажиллаж байгаа болон дуудлаганд гарах хугацааны дундаж хүлээгдэл 5-6 минут байна. | 100 |
| | | | | Яаралтай дуудлагын 20 минутын очилтын хувь | 83 | 85 | 2026 оны 06 дугаар сарын 01-ний байдлаар:<br>- Яаралтай тусламжаар 808<br>- Түргэн тусламжийн дуудлага | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 1405 бүртгэн авч тусламж үйлчилгээг үзүүлэн ажилласан ба дуудлаганд 20 минутын очилт 83,9%-тай байна.<br>20 минутаас дээш хугацаанд очсон дуудлаганд 16,1%-ийг эзлэж байна. Тус дуудлаганд дүгнэлт хийхэд<br>- Дуудлага давхардсан 34%<br>- Дуудлага очих замын км зайнаас шалтгаалсан (хөдөөгийн малчид, өртөө зөрлөгийн иргэд) 59%<br>- Бусад шалтгаан 7% байна. | |
